

TMC CONNECT

May 2015

ОЮУТНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА

Hawthorn хэлний сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагаа



Hawthorn хэлний сургууль гадуур хичээллэх үйл ажиллагааг зохион байгуулдаг. Англи хэлийг хичээл дээр зөвхөн үзэхээс гадна гадуур явж англи хэлний дадлага хийх боломж олгож мөн адил түвшиний оюутнуудтайгаа илүү дотносох боломж олгодог. Аялалын дараагаар оюутнуудад өөрсдийн аялалын туршлагын талаар тэмдэглэл бичих гэрийн даалгавар өгдөг. Энэ удаа бид гадуур хичээллэх явцдаа шинжлэх ухааны төв, цасны хот, Pulau Ubin, Сэнтасо аукариум, сингапурын амьтны хүрээлэн, хятад хороолол, бяцхан энэтхэг, Араб гудам зэрэг олон төрлийн газруудаар аялаж мөн барбикюү, мөсөн скэйт, боулинг, дугуй унах зэрэг төрөл бүрийн спортоор хичээллэсэн.

Гадуур хичээллэхээс гадна оюутнууд 3 сар тутам зохион байгуулагддаг Hawthorn сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөрт хамрагддаг. Энэ удаагийн үйл ажиллагаа маань “Энх тайвны диваажин” сувилалын газарт очин сайн дураар тусалж оюутнууд маань сувилалын газрын хүмүүстэй цагийг хөгжилтэй өнгөрөөж тэдэнд урам өгч байсан юм.

Сингапурын бартендер & ахлах үйлчлэгчийн холбооны воркшоп



2015 оны 4 сарын 1 нд, Сингапурын бартендер & ахлах үйлчлэгчийн холбооноос TMC-ABSS залуу гишүүддээ зориулсан анхны воркшопоо зохион байгууллаа. Алкоголгүй ундаа болон коктейлны найруулан бэлтгэгч, нийлүүлэгч Ноён Luke Jones оюутнуудад дээд зэрэглэлийн коктейл хийх төрөл бүрийн сиропыг танилцууллаа. Мөн оюутнуудад бүгдэд нь амсаж үзэх боломж олгосон юм. Коктейл хийх аргыг үзүүлж материал болон тоног төхөөрөмжийг мөн оюутнуудад танилцууллаа. TMC-ABSS залуу гишүүд коктейл хийх дадлаганд хамрагдан Ноён Jones тай туршлагаасаа хуваалцаж байсан юм.

Воркшопны дараа зочид буудлын менежментийн higher diploma-н оюутнууд ноён Alvin Ng-г TMC-ABSS залуучуудын ахлагчаар томилсон юм. Ноён Ng-д бүгд баяр хүргэж байлаа.

Үдийн цайны яриа



Компаниас сайн дураар зохион байгуулдаг ажилчидын эрүүл мэндэд зориулсан үдийн цайны яриа хөтөлбөр 2015 оны 3 сар болон 4 сард 2 дахь удаагаа хүний нөөцийн албанаас зохион байгуулагдлаа.

Анхны яриаг Сингапур улсын эмнэлэгийн хөгжимөөр эмчилдэг мэдрэлийн эмч лекц тавьсан бөгөөд гол агууллага нь цайны цагаар стресснээс гарах болон дахин эрч хүчтэй болох мөн өөрийгөө тайвшруулахад зориулсан хөгжим сонсох арга зэргийг тайлбарлаж өгсөн юм.

Хоёр дахь удаагийн 4 сарын ярианд эрүүл мэндийн боловсролын төлөөлөгч Шинэ

ээжүүдэд зориулсан зөвлөмж'-ийн талаар ярьлаа. Бие бялдар, сэтгэл санаа, оюун санааны бэлтгэлийг хүүхэддээ тохируулан хийх аргыг суралцлаа. Ажил хийдэг ээжүүдэд ээжийн үүргээ хэрхэн биелүүлэх талаарх мэдлэг туршлагыг бүгдийг тайлбарлаж өглөө.

Хоёр яриа нь оролцсон хүмүүст маш их хэрэгцээтэй мэдээллийг өгсөн юм.

Жоггинг буюу алхалтын спорт



ТМС ажилчидын баг хэдэн сар амрасны дараагаар 4 сарын 8 нд алхалтын спортоор дахин хичээллэж эхэллээ. Энэхүү хөтөлбөр нь ажилчидын эрүүл мэндэд туслах болон гишүүд хамтран ажиллагсадтайгаа хамт эрүүл амьдрахад туслах зорилготой юм.

Ажилчид Бишаны Анг Мо Кио паркаар жоггинг хийлээ. Ажлын дараа ядарсан боловч бүгд албан ёсоор оролцон алхалтын спорт болох жоггингоор бүгд хичээллэсэн юм.



Тайландын оюутнуудын айлчлал



2015 оны 3 сарын 17 өдөр ТМС Академи нь Тайландын Poolcharoenwitthayakhom сургуулийн айлчлалыг хүлээн авлаа. Багш сурагчид манай Бишан кампуст айлчилж 8-9-р ангийн сурагчидад сургуулийн хөтөлбөрийн танилцуулга хийлээ.

Тус сургуулийн захирал Тайландын уламжлалт зургийг дурсгал болгон бэлэглэж бүгд хамтдаа зургаа авхуулсан юм.

Япон сурагчидын айлчлал



Японы Фүкүока хотын бага сургуулийн сурагчид 3 сард манай сургуульд айлчиллаа. Тэд 1 долоо хоногийн богино хугацааны хэлний хөтөлбөрт хамрагдсан юм.

Англи хэлний хичээлдээ идэвхтэй оролцож өөр хэв маягаар англи хэл сурлаа.

Сурагчидтайгаа дахин уулзахыг хүсэн ерөөе.

Сингапурын сэтгэл судлалын холбооны гишүүнчлэл



2015 оны 3 сарын 28 нд Сингапурын сэтгэл судлалын холбоо болон ТМС Академи нь жил бүр зохион байгуулагддаг SPS уулзалтаар MOU-д гарын үсэг зурлаа. MOU нь ТМС-ын сэтгэл судлалын бакалавр болон дипломын сургалтын оюутнууд сэтгэл судлалын холбооны гишүүн болох боломжтой гэсэн үг юм.

Сингапурын сэтгэл судлалын холбооны тэргүүн Хатагтай Clare Yeo болон ТМС Академийн захирал Доктор Chin Kon Yuen нар хамтрах гэрээ байгуулан гарын үсэг зурлаа.

Доктор Chin энэхүү өдөр “Сингапурын сэтгэл судлалын холбоотой хамтран ажиллах болсондоо маш их баяртай байна мөн манай сэтгэл судлалын бакалавр болон дипломын сургалтын оюутнууд тус төвд гишүүн болон орохын тэсэн ядан хүлээж байна. Сэтгэл судлалын талаар Сингапурчууд сүүлийн үед маш их сонирхох болсон бөгөөд ТМС ын сэтгэл судлалын оюутнуудаар дамжуулан тус холбооны гишүүд улам их өсөх болтогуй гэж хүсч байна.” гэж хэллээ.

ТМС ACADEMY-ИЙН ТУХАЙ

ТМС Academy нь 1981 онд Сингапур улсад байгуулагдсан. Бид та бүхэнд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн Бизнес болон менежмент, Англи хэлний сургалт, GCE 'O' Level, Үйлчилгээ болон аялал жуулчлалын менежмент, Мэдээллийн технологи, Хууль, Сэтгүүл зүй болон Сэтгэл зүй зөвлөгөөний хөтөлбөрүүдийг санал болгож байна.

БИДНИЙ АЛСЫН ХАРАА

Амжилттай чадварлаг оюутнуудыг төгсгөж шилдэг сургууль болох.

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид үйлдвэрлэлд тулгуурласан тухайн орчин нөхцөлд тохирсон мэдлэг боловсролыг санал болгож байна.

БИДНИЙ ГОЛ ЗҮЙЛ

Мэргэжлийн ур чадвар – Бид ёс суртахуун, хариуцлага, ил тод байдлын хамгийн дээд зэргээр баримталдаг.

Ойр байдал – Бид харилцааг эрхэмлэдэг бөгөөд бие биедээ гэр бүлийн гишүүд шиг тусалж дэмжихийг эрмэлздэг.

Тасралтгүй хөгжүүлэх – Бид хамгийн шилдэг нь байхын тулд тууштай байж мөн үргэлж өөрсдийгөө шинэчилж хөгжүүлж байдаг.

Бидний үүрэг – Бид ТМС Академийн элч нар бөгөөд бидний үүрэг бол ТМС академийг улам боловсронгуй болгож хөгжүүлэх юм.